



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Г

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийг байгуулж, бүрэлдэхүүнийг томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.3, 65.6 дахь хэсэг, "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 4.5, 5.6, 5.7 дахь заалт, "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 2.2, 2.4, 2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийг Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэд байгуулсугай.

2.Салбар зөвлөлийн дарга, гишүүн, нарийн бичгийн даргыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Салбар дарга:	Д.Мөрөн-Гадаадын иргэн, харьяатын газрын дарга,
Гишүүд:	Д.Түвшинтөр-Гадаадын иргэн, харьяатын газрын дэд дарга, Д.Давааням-Гадаадын иргэн, харьяатын газрын Захиргаа, удирдлагын газрын дарга, Ч.Нармандах-Гадаадын иргэн, харьяатын газрын Виз, зөвшөөрөл, харьяатын газрын дарга, Н.Баянмөнх-Гадаадын иргэн, харьяатын газрын Хяналт шалгалтын газрын дарга, Б.Даваажав- Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүү, хангалт үйлчилгээний газрын дарга, Ч.Тулгацоодол- Гадаадын иргэн, харьяатын газрын Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн дарга, Л.Батсүх- Гадаадын иргэн, харьяатын газрын Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтсийн дарга, Ж.Алтангэрэл- Гадаадын иргэн, харьяатын газрын Захиргаааны удирдлагын газрын Хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн.
Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга	Ж.Алтангэрэл- Гадаадын иргэн, харьяатын газрын Захиргаааны удирдлагын газрын Хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн.

3.Төрийн албаны тухай хууль тогтоомж, "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга /Д.Мөрөн/-д даалгасугай.

20000074

ТАЗ тогтоол 2020

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоол, “Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн даргын 2016 оны 105 дугаар тушаал, “Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн даргын 2018 оны 17 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ